



МОНГОЛ УЛСЫН НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2001 оны 01 дугаар
сарын 31-ны өдөр

Дугаар 58

Улаанбаатар хот

"Инфоком төв"-ийг татан буулгах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 2 дугаар заалт, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тэргүүлэгчдийн 2001 оны 09 дүгээр тогтоолыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ :

Нэг. "Инфоком төв" нийслэлийн өмчит үйлдвэрийн газрыг 2001 оны 1 дүгээр сарын 31-ний өдрөөр тасалбар болгон татан буулгаж, Нийслэлийн Засаг даргын дэргэдэх Статистик мэдээлэл, судалгааны газрын бүтцэд оруулан нэгтгэн зохион байгуулсугай.

Хоёр. Өр авлагатай байгууллага, хүмүүсийн жагсаалтыг гарган, хаалтын балансыг 2001 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн дотор ирүүлэхийг "Инфоком төв"-ийн захирал У.Тамир-д даалгасугай.

Гурав. Жаргалсайханы Тамирыг "Инфоком төв"-ийн захирлын үүрэгт ажлаас 2001 оны 2 дугаар сарын 01-ний өдрөөр тасалбар болгон чөлөөлсүгэй.

Дөрөв. Ажил хүлээлцүүлэх, өмч хөрөнгийг Статистик мэдээлэл, судалгааны газарт хүлээлгэн өгөх комиссын бүрэлдэхүүнийг хавсралт ёсоор баталсугай.

Тав. "Инфоком төв"-ийн авлага, өр төлбөрийг хариуцахыг Нийслэлийн Засаг даргын дэргэдэх Өмчийн харилцааны газар П.Дэлгэрнаран-д үүрэг болгосугай.

Зургаа. Энэ захирамж гарсантай холбогдуулан нийслэлийн Засаг даргын 1997 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн А/219 тоот захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР
ХОТЫН ЗАХИРАГЧ

М.ЭНХБОЛД



Нийслэлийн Засаг даргын 2001 оны
01р сарын 31ны өдрийн 58 дугаар
захирамжийн хавсралт

**“ИНФОКОМ ТӨВ” УУГ-ийн АЖИЛ ХҮЛЭЭЛЦҮҮЛЭХ,
ӨМЧ ХӨРӨНГИЙГ ХҮЛЭЭЛГЭН ӨГӨХ
КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН**

Комиссын дарга	Ж.ЭРДЭНЭБААТАР Нийслэлийн Өмчийн харилцааны газрын Төлөөллийн хэлтсийн дарга
Нарийн бичгийн дарга	Ш.ЭРДЭНЭБИЛЭГ Нийслэлийн Өмчийн харилцааны газрын Төлөөллийн хэлтсийн мэргэжилтэн
Гишүүд	Ч.БАЯНЧИМЭГ Нийслэлийн Статистик мэдээлэл, судалгааны газрын дарга
	Ш.ГАНТӨМӨР СМСГ-ын сүлжээ, программ хангамжийн асуудал хариуцсан мэргэжилтэн
	С.СОЛОНГО НЗДТГ-ын Санхүүгийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн
	Б.ГАНЦЭЦЭГ НЗДТГ-ын Эдийн засаг, стратегийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн